

Эелдэг харьцаа эх хэлнээс эхтэй

Г.Гэрэлмаа

Замын түгжээнд зогсохдоо бие биеэсээ зандарч загнах жолооч нар, хажуугаар өнгөрөх дунд сургуулийн сурагчийн

–Утас аа аваач тэнэг минь ... гэж найздаа хэлэх доромж үг, албан хаагчаа дарга нь дуудаад мэндийн хариугүй дүрэмдэх басамж үг гээд тоочоод байвал гудамж талбай, албан өрөөнд хүртэл зүй бус харьцааны зүү шиг үгс алхам тутамд тааралдах юм. Бүдүүлэг үг хүйтэн харьцааг хүлээн авсан хэн ч байсан өдөржин сэтгэл гутрал, уур бухимдалаар дүүрэн, бүлх залгисан юм шиг бүүдийж урам зориггүй явна. Зан харьцааны энэ мэт байдал, үг хэлний хатуу ширүүн нь нэгээс нөгөөд улмаар нийтэд нөлөөлж нийгмийн стресс буюу бухимдал үүсгэдэг шалтгаан нөхцөлийн нэг болсоор. Манай улсад амь албаар ирж очдог гадныханд "Монгол хүн их ууртай, догшин" гэсэн ойлголт аль хэдийн бий болжээ.

Монгол хүний харьцааны соёл ийн доройтох учир чухам юунд оршино вэ? Ямар боловч энэ тухай нухацтай бодож, хэлэлцэж, дор бүрнээ хичээж, одоо л зөв тийш нь эргүүлэн зүгшрүүлэхгүй бол оройтох нь ээ.

Харьцааны соёлын эхлэл бол мэнд мэдэх. Түвшин сайхан мэндэлсэн хүнтэй ярьж хөөрч, санаа бодлоо ойлголцоход амар. Нүүдлийн мал аж ахуйг олон зуунаар эрхэлсэн монголчуудын мэндлэх ёс нь зөвхөн тухайн нэг хүний мэндийг мэдэхээс илүүтэй цаг улирал, ажил алба, мал ахуйтай холбон мэндчилдэгээрээ онцлог. Дөрвөн улирлын турш нүүдэллэн амьдрахдаа цаг улиралд тохирсон –Сайн байна уу?, Та сайхан хаваржиж байна уу, Сайхан зунжиж байна уу гэх буюу Мал тарган, сүрэг мэнд үү, Тарган тавтай өвөлжиж байна уу гэх мэтээр мэндлэх нь хүний эрхэлдэг аж ахуй болох малын тарга хүчийг хүний байр байдалтай нь зэрэгцүүлэн товч тодорхой асуудаг.

Хөдөө мал хариулж яваа хүн хээрийн хойморт уулзаад мориноосоо бууж хөөрөг зөрүүлэн мэнд усаа мэдэлцэн, малын тарга хүч, цаг улирлын байдлаа ярьж хөөрөлдөн суудаг байсан бол орчин үед бидний ахуйн хэвшил өөрчлөгдөж, монголчуудын ихэнх нь мал адуулахаа больж хотод суурин амьдрах болсноор ахуйтай холбоотой уламжлалт мэндийн үгийг хэрэглэх боломжгүй болж байна. Хотын бидэнд тэгэж тайван ярьж суух цаг хугацаа богино давчуу тул, гудамжинд зөрөхдөө түргэн зуур мэндээ мэдэлцээд өнгөрөх нь элбэг.

Ийм хотжих үйл явцын хурдтай хөл нийлүүлсэн бид өөрөө хоорондоо зөв мэндчилж сурахаас үр хүүхдийн минь харьцааны соёл төлөвших нь дамжиггүй.

Тэгээд хүүхэд хэрхэн юу ярьж, яаж эхэлж хэлд ордог талаар бага сага ажиглалт хийлээ. Ингэхэд хүүхдийн анхны хэлж сурч буй үг нь май, юм гуйхдаа –надад өгөөч гэж хэлдэг хүүхэдтэй бараг тааралдсангүй, шууд л –**өг, миний** гээд авах нь олонтоо. Цаашлаад хэлж буй үг хэллэгийг нь сонсвол үйл үгийн захиран тушаах хэлбэрээр –**боль, -ав, -битгий** гэх мэт захирсан хөгтэй үг хэлж сурсан байх юм. Эцэг эхчүүд бид хүүхдээ хүмүүжүүлэхдээ ямар нэгэн юм авахаар нь –боль, битгий гэж хашхираад л яагаад болдоггүй учрыг ерөөс тайлбарлаж өгөхгүй, ах эгч нар нь ч балчир дүүгээ –**чи зайл, -холд**

-боль гэхээс өөр үгээр харьцахгүй болохоор тэр нялх амьтан чихэнд сонсогдож сурсан үгээ хэлэх нь аргагүй шүү дээ.

Захиран тушаах үйл үгийн өгүүлэх төрх байдал нь хөмсгөө зангидсан, албархуу хүйтэн царайгаар дууныхаа өнгийг өндөрсгөж харьцахаас аргагүй хэлбэр юм. Бид хичнээн их ажилтай яаруу тэвдүү явлаа ч уурлаж бухимдаад явах юм бол амьдралын баяр баясгалан тэр хүний чухам нь хаана нь байх юм бэ. Яаруу бачимдуу зан үр хүүхэд хойч үед минь өсөх наснаас нь эхлэн нөлөөлж насанд хүрээд ирэхэд нь хүний үг сонсогддоггүй хэг ёг гэсэн хэгжүүн залуус болгон өсгөж өндийлгөж байна.

-Эхнэр нь нөхөртөө – Чи цэцэрлэгээс хүүхдээ ав гэвэл, -Чи өөрөө авахгүй юу гэдэг ч юм уу ямар нэгэн хэрүүлийг үг бодогдоод явчихна. Харин –Миний хань өнөөдөр хүүгээ авчих уу гэвэл шал өөр хариулт бодогдоод явчих жишээтэй.

Соёлт хүн төрөлхтөний нэг илэрхийлэл нь хэл ярианы соёл, түүнийг хэрэглэх байдгийг энд дурдах юун. Хэл ярианы соёлыг дэлхий нийтээр чухалчилж эелдэг хэл яриа(polite language), эелдэг үг хэл (polite words) хэмээх ойлголтыг бий болгож, хөгжүүлж байна. Тийм ч учраас хүүхдүүддээ эелдэг харьцааны хэдхэн үгийг юун түрүүнд хэлүүлж сургадаг байна.

Сайн байна уу, Hello

Энэхүү мэндийн үгийг хүүхдэд зааж өгөхдөө найз нартайгаа, ахмад хүмүүстэй хэрхэн мэндлэхийг ялгаж зааж өгдөг байна. Монголчууд бид дөнгөж хэлд орж буй хүүхдэдээ аав, ээж, эмээ, өвөө, өг, ав гэх зэрэг наад захын үг заахаас биш, найзтайгаа ингэж мэндэл, ахмад хүмүүстэй ингэж мэндэл гэж зааж өгөх нь ховор юм. Өөрөөсөө ахмад хүнтэй мэндэлэхдээ –Та сайн байна уу гэх бол найзтайгаа –Сайн уу гэж мэндлэж сургах нь зүйтэй.

Бидний ярианы хэлэнд – Сайн уу, Юутай вэ гэх хэллэг өргөн хэрэглэгддэг. Сонин сайхан юутай вэ гэж асуусан үгийн хураасан хэлбэр боловч үгийн сангийн утгаараа “Чамд юу байна” гэж асуугаад байгаа ч юм шиг, хариулт нь бүр ч эвгүй, “юмгүй” гэхээр юу ч байхгүй хүн мэт сэтгэгдэл төрөөд монгол хүний “амны билгээс ашдын билэг” гэх ойлголтонд таарахгүй болж байна.

Баяртай, Good bye

Нэгэнт мэнд мэдээд уулзсан хүмүүс явахдаа баяртай, дараа уулзая гэж хэлдгийг хүүхдэдээ сургах нь зүйтэй. Уламжлалт салах ёсны үгэнд –Замдаа сайн яваарай, Аян зам тань өлзийтэй байг гэх зэрэг сайхан ерөөлийн үгтэй хамтатгана.

Болох уу, Please

Энэ хэллэг нь хүүхдийг аливаа зүйлийг хийхдээ зөвшөөрөл хүсч, -Үүнийг авч болох уу, түүнийг үзэж болох уу хэмээх хэлдэг дадалтай болгодог онцлогтой. Ингэхгүй аваас хүүхэд дураараа загнаж бүхнийг өөрөө авах ёстой мэтээр сэтгэж, дэлгүүр хоршоонд орсон ч гэсэн бүгдийг авах ёстой мэтээр боддог болчихдог. Хэрэв ингэж асуугаад сурсан

хүүхэд хүний юманд дураараа халдаж, өөрийн болгох гэхгүй, асууж байж авдаг болдог. Энэ хүмүүжил нь том болоод төлөвшиж зөв болосвон хүн болоход нөлөөлөх юм.

Баярлалаа, Thank you

Хүүхэд хоолыг нь хийгээд өгсөн ээждээ, цэцэрлэгт нь хүргэж өгсөн аавдаа баярлалаа гэж хэлүүлж сургах арга. Үүнийг аав ээж нь үлгэрлэж хүүхдээ жаахан тус хүргээд, нэг юм аваад өгөхөд нь хүртэл -баярлалаа, миний хүү гэж хэлэх нь орчноосоо суралцах, түүнийгээ хэвшүүлэх боломж юм аа.

Монголчуудад талархснаа илэрхийлэх үг хэллэг цөөнгүй бий. Настай хүмүүс залуу дүүмэд хүнд хэлэхдээ “гялайлаа” гэдэг бол, албан ёсны үйл ажиллагаанд “талархаж байна” гэж, ярианы хэлэнд “баярлалаа” гэх зэрэг уламжлалт сайхан үгсийг хэрэглэх нь зүйтэй.

Зүгээр дээ, You're Welcome

Ямар нэгэн хүн талархсанаа илэрхийлэхэд эргүүлээд –зүгээр ээ хэмээн хэлүүлж сургах.

Гялайлаа, баярлалаа гэдгийн хариуд –За зүгээр ээ, -зүгээр зүгээр гэх мэтээр хариу барьдаг

Уучлаарай, I'm Sorry

Энэ хэллэгийг ямар нэгэн алдаа хийсэн тухайд зөвхөн хэрэглэх биш, хүссэн гуйсан, үгээ хэлэх зөвшөөрөл эрсэн зэрэг олон тохиолдолд хэрэглэх тул хүүхдэд хэлүүлж хэвшүүлэх эелдэг үгийн тоонд багтжээ. –Би даалгавраа хийгээгүй уучлаарай багш аа, - Хувцсаа муухай болгочихлоо уучлаарай ээж ээ гэх зэрэг нь хүцэл өчиж буй боловсон хэлбэр юм.

Монгол хэлнээ дээрх тохиолдол болгонд уучлаарай гэж хэлэхгүй, -тэгэж болох уу, саналаа хэлэх гэсэн юм гэх зэрэг үгийг нөхцөл байдалд нь тохируулан хэрэглэнэ.

Хэдийгээр эелдэг харьцааны үг хэллэг хэмээн нэрлэж буй боловч үгээр дамжин хүмүүний харьцааны соёлыг хүүхэд наснаас нь гэдэг соёлт хүн төрөлтхтөний өмнө Монгол түмний ирээдүйг бэлдэж байна гэсэн үг .